



Г.Пүрэвсүрэн
БХИС-ийн Цэргийн Командын Сургуулийн Цэргийн сэтгэл зүйн тэнхимийн
багш, магистр

ОЮУТНЫ МЭРГЭЖИЛ СОНГОЛТЫН СЭДЛИЙН ТАЛААРХ ОНОЛ АРГА ЗҮЙН АСУУДАЛД

Abstract: The choice of profession depends on external or internal motives, which are made to each other, and coordinated. The most important part is motivation of public communication then its understandable character for individual person. This motivation influences on the choice of profession categories: internal – individual and social factors; external – optimal or passive.

Key words: students, profession, education, professional orientation, choice of profession, motivation for choice of profession.

Удиртгал

Аливаа улс орны хөгжилд шууд нөлөөлөгч гол хүчин зүйлийн нэг бол нийгмийнхээ эрэлт хэрэгцээнд бүрэн тохирсон, чадварлаг мэргэжилтэн, эдгээр мэргэжилтнийг бэлтгэдэг боловсронгуй сайн тогтолцоотой байх явдал юм. Аль ч улс орны хувьд мэргэжлийн боловсролын асуудал нэн чухлаар тавигддаг. Учир нь энэхүү асуудлаас иргэдийн амьжиргаа, айл гэрийн сайн сайхан байдал, улс орны хөгжил дэвшил шалтгаалж байдаг. “Хот орны” түршилтаараа нэрд гарсан хүний харилцааны онолыг үндэслэгч Эльтон Мэйо /1952/ хэлэхдээ: “Ажилтны бүтээмжийн үр ашгийг сайжруулахыг эрхэлсэн менежер хүн, хүний бүтээмж сайжрах, амжилтад хүрэх үндэс болсон хүний сэтгэл санаанд анхаарлаа хандуул” гэжээ.

Сурч байгаа мэргэжил, хийж буй ажлынхаа үүрэг зорилгыг хэр зэрэг мэдэж, хэрэгжүүлж чадаж байгаагаар хүний, нийгэмдээ эзлэх байр суурь тодорхойлогдоно. 1990-ээд он буюу шилжилтийн он жилүүдэд мэргэжил эзэмших гэсэн сэдэл нь мэдлэг, мэргэжил эзэмшихдээ гол нь биш зөвхөн дипломтой болох гэсэн сэдлээр солигдож байжээ. 1994 оны үед сэдлийн бүтцийн хувьд ихээхэн өөрчлөлт орж өндөр соёлтой, боловсролтой байх гэсэн сэдэл 58%,

амьдралд амжилт олох гэсэн сэдэл 54%, албан тушаал хөөцөлдөх, дэвших гэсэн сэдэл 37%, нийгэмд тодорхой байр суурь, нэр хүндтэй байх гэсэн сэдэл 20% байсан ч тодорхой мэргэжил эзэмших гэсэн сэдлийн хувьд 41%-тай байсан нь социологичдын судалгааны дүнгээс харагдаж байна.

Орчин үеийн нийгмийн өөрчлөлт, хөгжлөөс үүдэн хүмүүсийн гадаадад сурч мэргэжил эзэмших, ажиллаж, амьдрах гэсэн хүсэл эрмэлзэл ихээхэн газар авч их, дээд сургуулийн суралцагчдын 48% нь гадаадад ажиллаж амьдрахыг хүсэж байгаа нь социологийн судалгааны дүнгээс харагдаж байна. Оюутны мэргэжил сонгосон байдалд анхаарлаа хандуулахад нийгмийн ухааны чиглэлээр суралцаж буй оюутан ихэнх тохиолдолд өөрийгөө хөгжүүлэх, мэдлэгийн хүрээгээ тэлэх, боловсрол эзэмших ихээхэн сонирхолтой байдаг бол харин техникийн чиглэлийн оюутан тодорхой чухал шаардлагатай мэргэжил эзэмших, улмаар тухайн мэргэжлээрээ өсөж хөгжих хүсэл эрмэлзэлтэй байгаа нь харагдаж байна. Энэ асуудлаар нэлээд дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийхийн тулд мэргэжил сонгож буй сэдэл, оюутны амьдралын ерөнхий төлөвлөгөө, дээд боловсролтой мэргэжилтнүүдийн чанар байдалд анализ хийх хэрэгтэй юм.

Хүн өөрийн сэтгэл зүйн онцлог, хэв шинж, хүсэл сонирхолд нийцсэн мэргэжлийг сонгох нь амжилтад хүрэх нэг үндэс төдийгүй мэргэжил сонголтын сэдлийн бүтцэд дотоод сэдэл давамгайлснаар оюутан суралцагчдын сурах сэдэл болон амжилтад хүрэх, цаашлаад сурах хандлагыг дэмжих гол хөшүүрэг болно гэж үзээд энэхүү сэдвийг сонгон авч судлахыг зорьсон болно.

Мэргэжлийн чиг баримжаа нь нийгэм, эдийн засгийн, хөдөлмөрийн зах зээл, боловсролын салбарыг хамарсан өргөн хүрээтэй ойлголт билээ. Мэргэжлийн баримжаа олгох ажил нь мэргэжлээ

оновчтой сонгох болон ажил, мэргэжлийн ертөнцтэй танилцаж, танин мэдэхэд туслалцаа үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, арга зүйн тогтолцоо юм. Өөрөөр хэлбэл, “Суралцагчдад хөдөлмөрийн ертөнцөд ирээдүйн мэргэжлийнхээ сонголт хийх боломжуудтай танилцуулж, зөвлөгөө мэдээлэл өгөх үйл явц”¹ хэмээн тодорхойлжээ. Энэхүү ажил үр дүнтэй явагдвал нийгэмд тогтвор суурьшилтай ажиллах, эрхэлсэн ажилдаа амжилт гаргах, хүн бүр өөрсдийн сонирхсон ажил хөдөлмөрийг эрхлэх боломж нэмэгдэхийн зэрэгцээ хувь хүний өөрийн үнэлэмж дээшлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Мэргэжил, түүнийг сонгох нь:

Нийгмийн хөдөлмөрийн хуваариар үүсэж бий болсон хөдөлмөрийн төрөл бүхэн зорилго чиглэл, хийж бүтээх зүйл, хэрэглэх багаж, тоног төхөөрөмж, ажиллах байр, нөхцөлөөрөө өөр хоорондоо ялгаатай бөгөөд хөдөлмөрийн төрөл тус бүрээс түүнд ажиллах хүний зан төлөвийн онцлог, бие бялдар, оюун ухаан, эв дүй, хөдөлгөөн, баримжааллын онцлогт тавигдах шаардлага ч ялгаатай байна.

Энэ бүхнээс үндэслээд мэргэжил гэдэг чухам юу вэ? гэдгийг хамгийн энгийн, товч утгаар нь тодорхойлбол: Мэргэжил (Латинаар-professio). Монгол улсын боловсролын багц хуулинд тодорхойлсноор мэргэжил нь тодорхой ажил, хөдөлмөрийг эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогц юм. Тодруулбал; мэргэжил нь дараах хэдэн шинжээр тодорхойлогдоно. Үүнд:

1. Тодорхой үйлдлийг цаг зуурын богино хугацаанд биш харин удаан хугацаанд гүйцэтгэх
2. Энэ үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай мэдлэг, тусгай боловсрол, дадал, арга барил, чадварыг шаардах
3. Мэргэжлийн үйл ажиллагаа нь тодорхой мэргэжлийн ёс зүй, зан төлөв, мэргэжлийн сонирхлыг бүрдүүлнэ.
4. Мэргэжил нь тухайн хүний нийгэмд эзлэх байр суурь, нэр хүнд болон нийгмийн статусыг тодорхойлох нэгэн шалгуур болно гэх мэт.

Мэргэжил сонголт: Энэ ойлголтыг бид мэргэжлийн чиг баримжаа, бусад нөлөөлөл, хүчин зүйлсийн үндсэн дээр бие хүний эцэслэн гаргаж байгаа шийдвэрийн хэмжээнд ойлгох болно. Сэтгэл судлаач, профессор Г.Сарантуяагийн үзсэнээр “Мэргэжил сонголт бол тухайн хүний сонирхол, авьяас, сэтгэл зүй, биеийн хөгжил, нийгмийн хандлага зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг” гэжээ.

Л.С.Выготскийн үзэж байгаагаар “Мэргэжил сонголт гэдэг нь ямар нэг мэргэжлийн үйл

ажиллагааны сонголт төдий биш нийгэмд өөрийн байр суурийг хайж олох, амьдралын замаа сонгох сонголт юм”. Энэ сонголтыг хийхийн тулд өөрийн авьяас мэдлэг, боломждоо анализ хийх, шийдвэр гаргах чадвартай, алс ирээдүйг бодсон санаа зорилготой байх зайлшгүй шаардлагатай.

Мэргэшил гэдэг нь мэргэжлийн хүрээнд ажил гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, чадварын түвшин юм. Өөрөөр хэлбэл, мэргэжлийн хөдөлмөрийн үйл ажиллагааны доторх тодорхой нэг чиглэлд дагнан мэргэжсэнийг мэргэшил гэнэ. Мэргэжил нь хөдөлмөрийн үйл ажиллагааны төрлийг заадаг бол мэргэшил нь тодорхой мэргэжлийн хүрээнд гүйцэтгэх ажлын хэлбэрийг тодотгоно.

Мэргэжлийн баримжаа гэдэг нь явцуу утгаараа хүн өөрийн байр байдлаа ухамсарласны үндсэн дээр тодорхой мэргэжил, түүнийг эзэмших арга замыг сонгох явдал юм.

Мэргэжилд тохирох чанар: Тухайн мэргэжил эзэмшихэд зохицсон хувь хүний сэтгэл зүй, бие физиологийн онцлогуудын цогцолборыг мэргэжилд тэнцэж, таарч тохирох чанар гэнэ³.

Мэргэжлээ зохицуулан сонгох: мэргэжилдээ хамгийн үр бүтээлтэй суралцаж, түүнтэй холбоотой үүргээ дээд зэргээр гүйцэтгэхийн тулд бие хүний хувийн онцлог, авьяас чадвар, үүсмэл болон төрөлхийн шинж чанарт зохицуулан мэргэжлээ шилэн сонгох явдал юм². Энэ нь ердийн сонгож авахаас /профвыбор/ ялгаатай. Мэргэжил зохицуулан сонголт нь тухайн мэргэжлийн шаардлага, түүнд бие хүний тохироо, мэргэжлийн шинж чанартай шууд холбоотой. Мэргэжлээ ухамсартай сонгоход доор дурдсан зарим гол асуудлуудыг харгалзан үзвэл зохино. Үүнд:

1. Нийгмийн хэрэгцээ, аймаг, хот, орон нутагт үлэмж хэрэгцээтэй мэргэжил, мэргэжилтэй боловсон хүчний шаардлага
2. Аль нэг мэргэжлээс хүний хувийн шинж чанарт тавигдах шаардлага
3. Өөрийн боломжийг сонгох гэж байгаа мэргэжилдээ тохирох эсэхийг нарийн бодож тооцох /эрүүл мэндийн байдал, авьяас чадвар, тухайн мэргэжлийг эзэмших бэлтгэл, сонирхол зэрэг/
4. Сонгосон мэргэжлээрээ цаашид өсөж, хөгжих боломж зэрэг юм.

Боловсрол гэдэг нь өргөн утгаараа нийгмийн үзэгдэл, хүн төрөлхтний хуримтлуулсан байгаль, нийгэм, техник, урлагийн тухай мэдлэг, чадвар, ёс суртахуун, соёлын түвшин, түүний хөгжлийн цар хүрээ, харилцааны хэрэгсэл бөгөөд ард түмний бүтээсэн үнэт зүйл, үйл ажиллагааны туршлагаас

¹ БШУЯ, УАТ, БХ. Хөдөлмөрийн зах зээл, сургалтын агуулгын стандарт, төлөвлөгөө, хөтөлбөрийн холбогдолтой нэр томъёоны толь. Уб., 2002

² Монгол улсын боловсролын багц хууль. Уб., 2002.

³ Галданцогт Ж. Сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох зарим асуудал. Уб., 1979.

⁴ Дагвадорж Д. Маркетинг зах зээлд хөтлөх түлхүүр ухаан. Уб., 1999.



хойч үеийнхний өвлөн авах, өвлүүлэх үйл явц, энэ үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байдаг харилцан үүрэг хүлээсэн байгууллагуудын тогтолцоо буюу бие даасан систем мөн³. Явцуу утгаараа суралцагчдад тодорхой түвшний мэдлэг, бүтээлч чадвар эзэмшүүлэх нийгмийн харилцааны үр дүн юм.

Сэдэл бол тухайн хүний үйл ажиллагаанд оролцох болсон шалтгааныг илэрхийлж байдаг учир мэргэжил сонголтод бас нөлөөлж байдаг. Польшийн сэтгэл зүйч Т.Томашевский мэргэжлийн үйл ажиллагааны сэдлийг дараах байдлаар ангилсан байдаг. Эдгээр нь:

- Үр өгөөжид чиглэсэн сэдэл
- Аюулгүй байдлын сэдэл
- Сэтгэл хангалуун байх сэдэл
- Бусдын санаа бодолд нийцэж байх сэдэл гэх мэт.

Мэргэжил сонголтод хандах хандлага түүний үндэс:

- Практик болон бизнесийн сэдлийн нөлөөлөл /энэ нь залуучуудын ертөнцийг үзэх үзэлтэй хамааралтай/

- Мэргэжлийн чиглэл нь ямар нэгэн их сургуулийг сонгох байдаг /мэргэжилгүй байснаас мэргэжилтэй байсан нь дээр/

- Нийгэмд эзлэх байр суурь /нийгэмд эзлэх нэр хүнд байр суурь өсөн дээшилдэг/

- Санамсаргүй байдлаар сонгох /Өрөө төлж байгаа байдлаар, дипломтой болох гэсэн эрмэлзэл/

- Залуучууд мэргэжлийн үр чадварыг гүйцэт үнэлж чадаагүйгээр сонгох /өөрийн хувийн онцлог, авьяас чадварт тулгуурлалгүйгээр/

- Бие даасан чанараа илэрхийлэх /бие хүн болсноо мэдэх-эцэг эхийн болон багш нарын оролцоог үл анзаарах/

- ЕБС-д байхдаа өөрийн суралцах чиглэлийг урьдаар төлөвлөж сонгоогүй

- Өөрийгөө доогуур үнэлэх чиглэл нь мэргэжлийн чиглэл хандлага дээр өөрчлөгдөөгүй.

Тодорхой мэргэжлийг сонгох, хувь хүний зүгээс аливаа мэргэжилд хандах хандлага нь мэргэжил сонголтын сэдэл гэдэг үндсэн ойлголттой салшгүй холбоотой байдаг бөгөөд энэхүү ойлголт нь хүн нэг бүрийн нийгмийн хариуцлагын тухайн нөхцөлд нийгмийн харилцаанд орж буй хамт олон, хувь хүний аливаа мэргэжлийг сонгосон байдалд дүн шинжилгээ хийхэд зайлшгүй авч үзэх ёстой сэтгэл судлалын ухааны шинэлэг судлагдахуун мөн гэж үзэж болно.

Мэргэжил сонголтын хувьд ухамсартай тунгаан бодсон сэдлийн үндсэн дээр сургуульд элссэн тохиолдолд тухайн оюутан сонсогч цаашдаа амжилттай суралцах уг мэргэжлийг

эзэмших тулгуур хүчин зүйл болно. Мөн түүнчлэн тухайн мэргэжлийнхээ нийгэмд үзүүлэх нөлөө, нөлөөлөл нийгмийн харилцааны хэв маяг зэргийг үндсэн агуулгаар нь сайтар ойлгосон байх учиртай. Мэргэжилтэн болох үйл явц нь ахуйн болон бусад ямар ч нөхцөл байдалд өөрийнхөө гаргасан мэргэжил сонголтын хувьд гуйвалтгүй байх сэтгэл зүйн чадвар нь тухайн хүний зан төлөв, авир араншинтай салшгүй холбоотой байх зэрэг олон сэтгэл зүйн нөлөөллүүдийг харгалзан үзэх шаардлагатай. Сэтгэл зүйн шинжлэх ухааны үүднээс сэдлийг олон янзаар ойлгож болно. **Мэргэжил сонголтын хувьд “сэдэл” нь тухайн мэргэжлийн үйл ажиллагааны онцлог, зэрэг сөрөг талуудыг сайтар ухамсарлан ойлгосон, сэтгэл зүйн онцгой хүчин зүйл гэж үзэж болох юм.** Бид мэргэжил сонголтын асуудлаар тухайн хүн сэтгэл зүйн хувьд өөрийгөө тодорхой ажил мэргэжилд бэлтгэж түүнд суралцах хүсэл эрмэлзэл төрүүлж буй сэтгэл зүй, оюун санааны сэдлийг олон талаас нь харгалзан үзэж судлах зайлшгүй шаардлагатай байна. Гэхдээ энэхүү мэргэжил сонголтын сэдлийн янз бүрийн нөлөөлөл, үүссэн тодорхой ахуйн хүрээний болон нийгмийн харилцаанаас нөлөөлөх хүчин зүйлийг харгалзан үзэх хэрэгтэй.

Орчин үеийн нийгмийн амьдралын бодит байдал нь тухайн оюутан сонсогчийн мэргэжил сонголтын сэдэлд гэнэтийн болон гадны шахалтаар өөрчлөлт үзүүлэх, маш олон хүчин зүйлүүд байдаг гэдгийг анхаарч, тэдгээрийг сэтгэл судлалын шинжлэх ухааны үүднээс тодорхойлон судлах зайлшгүй шаардлага тавигдаж байна. Мэргэжлийн үйл ажиллагааны үр дүн, үр чадвар зэрэг нь тухайн мэргэжлийг сонгох сонголт болсон сэдлийн нөлөө нөлөөлөл, уг хүний ухамсарт үйл ажиллагаанд тодорхой мэргэжил сонгоход нь нөлөөлсөн тулгуур хүчин зүйл болох ухамсарт сэдэлтэй салшгүй холбоотой юм. (үнэт зүйлс) Энэ агуулгаараа сэдлийг сэргээх, түүнийг тогтвортой байлгах чиглэлээр хийгдэх ажлын арга зүй, хэлбэр зэргийг сэтгэл судлалын шинжлэх ухааны онолын үндэслэлтэй олж тогтоох явдал нь ирээдүйн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэхэд туйлын чухал хүчин зүйл болж байна.

Тухайн хүний мэргэжил сонголтын сэдэл нь уг мэргэжлийнхээ хувьд олсон тодорхой амжилт, үр дүнгээр тэжээгдэн урамшин хөгжиж байдаг бол, бүтэлгүйтэл, тодорхой үр дүнд хүрээгүй байдал зэргээс улбаалан тухайн мэргэжилтний үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлдөг байна.

Мэргэжил сонголтын сэдлийн агуулгыг (үндсэн мэргэжлийн үйл ажиллагаа түүнд нөлөөлөх хүчин зүйл, сэдлийн бүтэц, үндэслэл, үйл ажиллагаа), гадаад сэдлүүдийн үйл ажиллагаатай холбоогүй атлаа (нийгмийн өмнө хүлээх үүрэг хариуцлага, өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа, нийгэмд эзлэх өндөр байр суурь, азгүйтэл бүтэлгүйтлийн

⁵ Бэгз Н. Боловсролын онол, арга зүйн асуудалд. Уб., 1996

байдлаас гарах хүсэл эрмэлзэл) зэрэг томоохон цогцолбор ойлголт юм гэдгийг хүлээн зөвшөөрч олон талаас нь онол, арга зүйн хувьд судлах зайлшгүй шаардлага тавигдаж байна.

Мэргэжил сонголтын хувьд сэдлийн хүчин зүйлүүдийг гадаад, дотоод гэсэн үндсэн хоёр хэсэгт авч үзэж болох бөгөөд эдгээр хүчин зүйл нь хоорондоо салшгүй холбоотой нэг нь нөгөөгөө нөхөж, харилцан нягт уялдаа холбоотойг анхаарч үзэх зайлшгүй шаардлагатай юм. Онцгой сонирхол татаж буй нь нийгмийн харилцаатай холбоотой сэдлүүд бөгөөд зөвхөн хувь хүнд л байх давтагдашгүй сэдэл юм. Мөн түүнчлэн хамт олондоо хандах хандлага, хамт олныхоо эрх ашгийг хүлээн зөвшөөрөх чадвар, хамт олны эрх ашгийг хангахад оруулах хувь нэмэр зэрэг олон ойлголтууд байна. Ийм хэлбэрээр мэргэжил сонголтын хувьд нөлөөлж байгаа сэдлийг дараах байдлаар ангилан авч үзжээ. Үүнд: дотоод (хувь хүний, нийгмийн хариуцлагатай холбоотой), гадаад (зерэг, сөрөг).

Орчин үед аливаа мэргэжил түүний үйл ажиллагаа өнөөдрийн хувьд ямар агуулгаараа үнэ цэнтэй байж болох вэ? гэсэн асуулт урган гарч байна. Үүнд нэгдүгээрт, цалин хөлс, өөрийгөө илэрхийлэх, бусдад таниулах боломж бололцоо тавигддаг байна. Нийгмийн энэхүү хүчин зүйлийг хувийн өмч, хувийн эрх чөлөөтэй салшгүй холбоотой гэж Т.Парсонс үзэж байна. ХХ зуунд оюутны мэргэжил сонголтод нөлөөлж буй хүчин зүйлүүдийг тоймлон судалж үзэхэд:

- Материаллаг сонирхол, түүний үзүүлэх нөлөөлөл яах аргагүй тавигдаж буй нь олон тооны судалгаа шинжилгээний дүнгээс харагдаж байна. Хүн өөрийн хүчин чадал оюуны чадавх нөөц бололцоондоо тулгуурлан аливаа мэргэжил мэдлэгийг сонгох үндсэн суурь хүчин зүйл болох ёстой боловч дараах нөлөөллүүдэд автан найз нөхдийн ятгалга, тухайн мэргэжлээр ажиллаж буй амжилт олсон, хөрөнгөжиж чинээжсэн, нийгэм хамт олонд танигдсан, хүмүүсийг даган дуурайх, тэдэнтэй өөрийгөө адилтгах гэсэн залуу насны хүсэл эрмэлзэл нь оюутан залуусын мэргэжил сонголтод нөлөөлөх томоохон хүчин зүйл болж байна

- Нийгэм улс төрийн амьдрал, үзэл суртал ухуулгын нөлөөлөл асар их өсөж, оюутан залуус ертөнцийг үзэх хатуу тогтвортой байр суурь төлөвшин тогтоогүй нөхцөлд тухайн мэргэжлийн уг чанар, цаашдын амьдралд нөлөөлөх нөлөөллөө тооцолгүйгээр мэргэжил сонголтод хандаж буй байдал ч илэрхий ажиглагдаж байна. Энэ тухай мэргэжил сонголтын асуудлаар судалсан эрдэмтэн судлаач **Г.Перкина**-ын бүтээлд тусгагджээ.

- Оюутан залуусын мэргэжил сонголтын үндсэн сэдлүүдэд ерөнхийдөө нийгмийн ухааны чиглэлийг түлхүү сонирхох байдал давамгайлж

байгаа нь нэг хэсэг тогтвортой ажиглагдаж байгаа боловч орчин үед мэргэжил сонголтод нарийн техник технологийн мэдлэг чадвар шаардсан мэргэжлүүд мэргэжлийн өндөр үр чадвартай гүйцэтгэх ажилтнуудын эрэлт хэрэгцээ ихсэж тэдний нийгэмд эзлэх байр суурь цалин хөлсний хангамж их байгаа нь залуусын мэргэжил сонголтод шууд нөлөөлж байгааг дурьдах нь зүйтэй. Энэ чиглэлээр эрдэмтэн судлаач **Э.Эриксон** "Сэтгэл зүйн төлөвшил ба мэргэжил сонголтод хандах хандлагын асуудал"-аар судалгааны ажил хийсэн байна.

ДҮГНЭЛТ

Энэ бүгдээс дүгнэлт хийж үзвэл сэдэл хэмээх ухагдахууныг олон талаас нь тайлбарлаж болох бөгөөд судлаачид гол төлөв хэрэгцээнд тулгуурлан үүсэж буй, үйл ажиллагааг өдөөгч дотоод хүч буюу хөдөлгүүр, түүнийг идэвхжүүлснээр сэдэлжилт явагдаж, хүний үйл ажиллагааг удирдан зохицуулах тодорхой үйл ажиллагаанд чиглүүлэн дайчлах үүрэг гүйцэтгэдэг байна. "Сэдэл нь аливаа хэрэгцээнээс үүдэн үүсэж хүний сэтгэцийн тогтвортой байдлаар дамжин тодорхой үйлдлийг гүйцэтгэхэд өдөөн идэвхжүүлэгч хүчин зүйл юм" гэж тодорхойлж байна.

1. Сэдэл, өөрийн хүсэл сонирхол, төлөвлөлт, тавьсан зорилгын дагуу үйл ажиллагаагаа чиглүүлж удирдахад **зохицуулах үүрэг** гүйцэтгэдэг бөгөөд хэрэгцээ, зорилго, хүсэл сонирхол, сэтгэл ханамж нь зохицуулалтын гол шалгуур болж өгдөг байна.

2. Сэдлийн бүтэц гэсэн ухагдахууны агуулгад сэдлийн хөгжлийн шатлал, давамгайлал өөрчлөлт, харилцан нөлөөлийн тухай ойлголт орно. Сэдлийн харилцан уялдаа холбоо, нөлөөллөл, өөрчлөлтийн зүй тогтлыг илрүүлэхэд сэдлийн бүтцийн судалгаа чухал ач холбогдолтой болж байна. Сэдлийн агуулга бүтцэд мэргэжлийн сонирхол давамгайлах хандлагатай байх юм бол илүү чармайн амжилтад хүрэх, сурах сэдэлд нөлөөлдөг байна. Мэргэжил сонголт болон суралцах, амжилтад хүрэх сэдлүүд нь харилцан уялдаа холбоотой бөгөөд мэргэжлийн сонголт, амьдралын үнэт зүйлс, өөрийгөө илэрхийлэх болон амжилтад хүрэх чиг хандлагад нөлөөлдөг болох нь харагдаж байна. Түүгээр зогсохгүй мэргэжлийн бэлтгэлжилт, бие хүний хувийн өсөлт бүтээлч идэвх хандлага нөлөөлдөг байна.

3. Сэтгэл зүйн шинжлэх ухааны үүднээс сэдлийг олон янзаар ойлгож болно. Мэргэжил сонголтын хувьд "сэдэл" нь тухайн мэргэжлийн үйл ажиллагааны онцлог, зерэг сөрөг талуудыг сайтар ухамсарлан ойлгосон, сэтгэл зүйн онцгой хүчин зүйл гэж үзэж болох юм. Бид мэргэжил сонголтын асуудлаар тухайн хүн сэтгэл зүйн хувьд өөрийгөө тодорхой ажил мэргэжилд бэлтгэж түүнд суралцах хүсэл эрмэлзэл төрүүлж буй



сэтгэл зүй, оюун санааны сэдлийг олон талаас нь харгалзан үзэж судлах зайлшгүй шаардлагатай байна. Гэхдээ энэхүү мэргэжил сонголтын сэдлийн янз бүрийн нөлөөлөл, үүссэн тодорхой ахуйн хүрээний болон нийгмийн харилцаанаас нөлөөлөх хүчин зүйлийг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Бэгз, Н. (1996). *Боловсролын онол арга зүйн асуудалд*. Улаанбаатар
- Галданцогт, Ж. (1979). *Сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох зарим асуудал*. Улаанбаатар
- Дагвадорж, Д. (1999). *Маркетинг зах зээлд хөтлөх түлхүүр ухаан*. Улаанбаатар
- Боловсрол Шинжлэх Ухааны Яам., ба бүс. (2002). *Хөдөлмөрийн зах зээл, сургалтын агуулгын стандарт, төлөвлөгөө, хөтөлбөрийн холбогдолтой нэр томъёоны толь*. Улаанбаатар
- Arestova, O. (1996, Sep). Informational Technologies and new trends of human development // 11nd Conference for Socio-Cultural Research Vygotsky-Piaget. Abstracts. Univ. of Geneva. 178
- Gleitman, H. (1992). *Basic Psychology*. 3rd edition. New York. N.Y.: Norton
- Ильин, Е.П. (2011). *Мотивация и мотивы*. Санкт-Петербург
- Хайруллин, Ф.Г. (2000). Некоторые проблемы формирования профессиональных интересов молодежи. Мотивация жизнедеятельности студента. Таллин, 69
- Хекхаузен, Х. (1986). *Мотивация и деятельность. Т.т. 1-2*, Москва, 240

